



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 01 сарын 18 өдөр

Дугаар A/02

Даланзадгад

Томуу томуу төст өвчний дэгдэлтийн үеийн
эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах тухай

Аймгийн засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/60 тоот захирамж “Боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох тухай”, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358 тоот тушаал “Томуу томуу төст өвчний улирал угтуулж болон дэгдэлтийн үед авах арга хэмжээний журам”-ын 2.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/438 тоот тушаал, амбулаторит томуу, томуу төст өвчин 22.1 хувийг эзэлж, хүндрэл нэмэгдэж, томуугийн тархалт сумын хэмжээнд хүрсэн байгааг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээнд онцгой анхаарч эрсдэлт бүлгийн хүн ам, ялангуяа 0-4 насны хүүхдийн гэрийн эргэлт, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настан, архаг хууч өвчтэй хүмүүсийн хяналтыг сайжруулж ажиллахыг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга эрхлэгч нарт даалгасугай.


2. Эмнэлгүүдийн яаралтай тусламж, эм тариа, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг нөөц боллоцгоонд тулгуурлан хангах ба шаардлагатай тохиолдолд асуудлыг шийдвэрлүүлэн ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Эмнэлгийн тусламж үйлчилгээг ажлын өдрүүдэд уртасгасан цагаар, амралтын өдрүүдэд тодорхой цагуудад үзүүлж, иргэдэд зөвлөгөө өгөх утсыг ажиллуулах, шаардлагатай тохиолдолд бусад мэргэжлийн эмч нарыг дайчлан ажиллуулахыг бүх шатны эрүүл мэндийн төвүүдийн дарга, эрхлэгч нарт даалгасугай.

4. Томуугийн 7 хоногийн эргэн мэдээнд дүн шинжилгээ хийж, эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, мэргэжилтнүүдийг эргэн мэдээллээр ханган ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс /Б.Мидэрсүрэн/, Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн байдалд үнэлгээ дүгнэлт өгч, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс /Ж.Отгонбайгал/, иргэдэд хандсан мэдээлэл сурталчилгааг оновчтой байдлаар хүргэхийг Нийгмийн эрүүл мэндийн төв /М.Булганчимэг/-д даалгасугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс /Б.Мидэрсүрэн/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ӨНӨРЖАРГАЛ